

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-14</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-14</i>
<hr/>	
<i>1. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>4-14</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын
04 дүгээр сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 34 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 55.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Амартүвшин, Т.Аубакир, Б.Бейсен, С.Ганбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Б.Жавхлан, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар;
Чөлөөтэй: Ж.Батсуурь, Ц.Даваасүрэн, С.Одонтуяа, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор, Ш.Раднаасэд.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын референт Д.Батсүрэн, мэргэжилтэн Д.Онолт, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Билгүүн, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга Г.Тулга, Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал, Үндэсний итгэмжлэлийн төвийн газрын дарга Г.Дамдинжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн

Ж.Бат-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Д.Амарбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Өнөрболор, Ц.Туваан, Ц.Сандаг-Очир, Т.Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “улаанбуудайн” гэсний дараах “баяжуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “улаанбуудайн” гэсний дараах “баяжуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 40 минут үргэлжилж, 34 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 55.9 хувийн ирцтэйгээр 19 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
18 цаг 25 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Төсвийн байнгын хороо хамтран хуралдахаар болсон байгаад байгаа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Төсвийн байнгын хорооноос Жигжидийн Батжаргал гишүүн, Цогт-Очирын Анандбазар гишүүн, хамтарснаараа явж байгаа юм байна.

Байгаль орчин болон Төсвийн байнгын хороо хамтарсан хуралд Хавдисламын Баделхан гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Хаянгаагийн Болорчулуун гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Гомтилдоогийн Мөнхцэцэг гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Батсүхийн Саранчимэг гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн, Төмөртоогогийн Энхтүвшин гишүүд хүрэлцэн ирснээр 2 Байнгын хорооны хамтарсан хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2 Байнгын хорооны хамтарсан хуралдааны ирц бүрдсэн тул

2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

2 Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 1 асуудал байгаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2024 оны 3 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой санал байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Дагшээвэгийн Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хаянгаагийн Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Болдбаатарын Билгүүн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Гансүхийн Тулга Стандартчилал тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга, Даваасүрэнгийн Батсүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт, Мангалсүрэнгийн Оюунжаргал Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга, Ганбүүрэгийн Дамдинжав

Үндэсний итгэмжлэлийн төвийн газрын дарга, Даваадоржийн Онолт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хурэлцэн ирсэн байна.

Ингээд Их Хурлын даргын 2024 оны 49 дүгээр захирамжаар Гаалийн албанаас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ гишүүн ажилласан байгаа. Ингээд ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүнийг микрофонд урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас нэн яаралтай горимоор 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 49 дүгээр захирамжаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах гурилын үнийг зохиомлоор нэмэгдүүлж байгаа эсэхэд хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор, Сандаг-Очир, Туваан,

Энхтүвшин нар, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиг үүрэгтэй ажлын дэд хэсгийн холбогдох байгууллагын 20 албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс 4 дүгээр сарын 18-ны өдрүүд ажиллалаа.

Ажлын хэсэг болон ажлын дэд хэсгүүд 2024 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Барс худалдааны захад гурилын үнийн судалгаа хийж, “Алтан тариа” ХК, “Миллхаус” ХХК, “Хангайн миллс” ХХК, “Од групп” ХХК-ийн гурилын үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан.

Түүнчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн газар, Стандарт хэмжил зүйн газар, ХАА-н корпорац, Үндэсний итгэмжлэлийн төв, “Гурил үйлдвэрлэгчдийн холбоо”-ны холбогдох мэдээллүүдийг сонслоо. Ажлын хэсэг 10 хоногийн хугацаанд холбогдох төрийн байгууллагуудын танилцуулга, мэдээлэлд үндэслэн санал, дүгнэлтийг боловсруулсан.

Гурилын үйлдвэрүүдийн анхан шатны баримт, агуулах нөөцөд тооллого явуулаагүй бөгөөд зөвхөн ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд орсон төрийн байгууллагуудын үндсэн мэдээлэл, танилцуулгыг нэгтгэх замаар санал, дүгнэлтээ боловсруулсан болно.

Ажлын хэсгээс улаан буудайн болон гурилын үйлдвэрлэлийн талаарх дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

1. Монгол Улсын хэмжээнд газар тариалангийн салбарт 2023 оны байдлаар 1398 аж ахуйн нэгж, 773 иргэн жилд дунджаар 361,4 мянган га талбайд улаан буудай тариалж, 443,4 мянган

тонн ургац хураан авч, 100 мянга гаруй ажлын байрыг бий болгосон байна.

2.Нийт 58 гурилын үйлдвэр тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс сүүлийн 5 жилийн байдлаар 12 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар 9 үйлдвэр болж цөөрсөн боловч 1480 ажлын байрыг бий болгож чаджээ.

3.Монгол Улсын 2023 оны гурилын хэрэгцээ 203,7 мянган тонн байсан бөгөөд 191,3 мянган тонн гурил дотооддоо үйлдвэрлэж, жилийн хэрэгцээнийхээ 94,5 хувийг хангаж, 5,5 хувь нь буюу 11.1 мянган тонныг импортын гурилаар хангажээ. Гурилын хэрэглээ болон нийлүүлэлтийн тоо хэмжээ сүүлийн 5 жилд ойролцоо байгаа нь гурилын нийлүүлэлт хэвийн буюу хомсдол үүсээгүйг харуулж байна.

4.Гурилын үйлдвэрүүдийн дундаж тооцоогоор 1кг улаан буудайнаас 75 хувь нь гурил, 22 хувь нь хивэг, 3 хувь нь хорогдол болдог.

5.Нэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн мэдээллээр 1кг улаан буудайн үнэ 2019-2023 онд 561-1018 төгрөг болж, 2022 онд хамгийн өндөр буюу 44 хувиар өсжээ. Сүүлийн 5 жилд өргөн хэрэглээний 1 дүгээр гурилын үйлдвэрийн үнэ 932-1701 төгрөг, зах зээлийн үнэ 1157-2316 төгрөг байж.

7.2024 оны 3 дугаар сарын байдлаар 1 дүгээр гурилын үйлдвэрийн үнэ 1940 төгрөг, зах зээлийн үнэ нь 2426 төгрөг болж байна. Дундын зуучлагч буюу дэлгүүр хоршоо сүүлийн 5 жилийн байдлаар 202,5-615,4 төгрөг буюу 20-36 хувийн өсөлтийн үнээр гурилын зах зээлд борлуулсан байна.

9.Бүх төрлийн гурилын үнэ 2022 оны сүүлийн хагас жилээс эхлэн 2023 оны эхний хагас жилд хамгийн их өсөлттэй байна. Аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангаас харахад үнийн өсөлтөд

голлон нөлөөлсөн хүчин зүйлс нь улаанбуудайн үнийн өсөлт, цалин, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал буюу бусад үйл ажиллагааны зардал зэрэг байна.

10.Монгол Улсын хилээр улаанбуудайн баяжуулсан гурил импортлоход аливаа тоо хэмжээний хязгаарлалтыг тогтоогоогүй байна. Харин энгийн баяжуулаагүй гурил нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Цагаан нуур, Боршоо, Арц суурь боомтоор 2024 онд 12 мянган тонн гурил импортлох зөвлөмж өгсөн бол харин экспортод хязгаарлалт тогтоохгүй байх зөвлөмжийг өгсөн байна.

12.Улсын Их Хурлын 2011 оны 19 дүгээр тогтоолоор гурилд ноогдох гаалийн албан татвар нь Баян-Өлгий аймгийн Цагаан нуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арц суурь, Говь-Алтай аймгийн Бургастай зэрэг 5 боомтоор жил бүрийн 7 дугаар сарын 1-ний өдрөөс дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл 15 хувиар, 4 дүгээр сарын 1-нээс дараа жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 5 хувиар гаалийн татвар албан татвар ноогддог. Дээрх 5 боомтуудаас бусад боомтуудаар гурил импортлоход 15 хувийн гаалийн татвар ноогддог байна.

Ажлын хэсгээс дараах дүгнэлтийг гаргаж байна.

1.Гурилын салбарт харьцангуй цөөн үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа тул цаашид өрсөлдөөнийг бий болгох зайлиггүй шаардлагатай бөгөөд өрсөлдөөний тухай хууль, тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага Шударга бус өрсөлдөөн хэрэглэгчийн эрх, ашгийн ашгийг зөв тогтоож, тогтолцоог өөрчлөх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх,

2.Монгол Улсын худалдааны төрөл, бүтэц, арга хэлбэр, гадаад болон дотоод худалдаанд тавигдах шаардлага,

худалдаа эрхлэгчдийн эрх, үүрэг, худалдаанд төрийн бус байгууллагын оролцоо, худалдааны бүртгэл, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, худалдааг төрөөс зохицуулах, дэмжих, хөнгөлөх зэрэг асуудлыг зохицуулах зайлиггүй шаардлагын хүрээнд Худалдааны тухай хуулийг шинээр боловсруулан батлах шаардлагатай байна.

3.Демпингийн эсрэг арга хэмжээг 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн дагуу эхлүүлэх, явуулах мөрдөн шинжилгээний үр дүнд демпингийн эсрэг хууль, тогтоомж болон дүрэм журмыг хуульчлан тогтоох хэрэгтэй байна. Дараах бараа, ажил, үйлчилгээг өөрийн өртгөөс нь хямд худалдан борлуулах замаар тухайн зах зээлд шударга бусаар өрсөлдөх монопол үүсгэх эрсдэлтэй тул демпингийн эсрэг эрх зүйн орчныг тодорхой болгох.

4.Газар тариалан эрхлэгч болон гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн хооронд арилжиж буй буудайн үнэ тогтоохтой холбоотой маргааныг эцэслэх зорилгоор буудайн арилжааг хөдөө аж ахуйн биржээр арилжих, тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судалж шийдвэрлэх.

5.Хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит ХХК-ийн элеваторыг тариаланчдад тариалан эрхлэгчдэд ашиглах боломжийг бүрдүүлэх,

6.Хүнсний улаанбуудайн стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор жил бүр тодорхой хэмжээний улаанбуудайг улсын нөөцөд худалдан авах.

7.Олон улсын жишигт нийцүүлэн импортын гаалийн албан татварын тоо хэмжээний хязгаарлалттай уян хатан бодлогоор хэрэгжүүлэх, зах зээлийн үнийн өрсөлдөөнийг бий болгох.

8.Гурил үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний улаанбуудайн чанарыг итгэмжлэгдсэн хараат бус лабораторийн сорилтын үр дүнд үндэслэн баталгаажуулах.

9.Импортыг орлох экспортод гаргах боломжтой улаанбуудайгаас бусад таримлуудын үр үйлдвэрлэлийн системийг хөгжүүлэх, тариаланчдыг тариалах арга, технологи сургах, техникийн өөрчлөлт, сонголтуудыг санал болгох ажлуудыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шуурхай эхлүүлэх.

10.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу гурилын болон улаанбуудайн стандартыг шинэчлэн боловсруулах.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийг боловсруулах, гурилын үнийг зохиомлоор нэмэгдүүлж байгаа эсэхийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгээс хуулийн төслийг хэрэгжих хугацааг тогтоох, хуулийн төслөөс баяжуулсан гэснийг хасах зарчмын зөрүүтэй 2 санал бэлтгэлээ.

Мөн хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний талаарх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэв.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн ахлагчийн санал, дүгнэлттэй холбогдуулж, хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Гишүүдийн нэрсийг авъя. Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая. Энэ асуудал орж ирээд хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн. Байнгын хороо болоод чуулганы хуралдаан дээр. Гэхдээ энд нэг асуудал бий. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл 2 зөрчхөөд байгаа. Чуулганы нэгдсэн хуралдаан дээр болоод Байнгын хорооны хуралдаан дээр үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гээд дэмжсэн. Тэгээд одоо манай ажлын хэсэг ажиллаад хуулийн төсөл дээр 2 зарчмын зөрүүтэй санал оруулаад ирж байна.

Тэгэхээр үзэл баримтлалаасаа зөрчхөөд байгаа. Үүнийг одоо Байнгын хороо чуулганаар анхны хэлэлцүүлэг хийж болох юм уу, болохгүй юм уу. Хуулийн төсөл үзэл баримтлалынхаа хүрээнд боловсрогдох ёстой. Хуулийн төслийн үзэл баримтлал баталсан 3 сайдын 2 нь үзэл баримтлалаасаа орж ирчхээд байгаа хуулийн төсөл зөрчхөөд байгаа гээд байгаа. Энэ дээр би хариулт авмаар байна.

2 дугаарт энэ хүнсний хангамжийн асуудал бол үндсэндээ үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Тийм ч учраас Хүнсний аюулгүй байдлын зөвлөл гэж зөвлөл байгаа. Энэ зөвлөлөөр Монголын гурилын хангалт дутааж байгаа, тодорхой хэмжээний гурил импортоор гаалийн татварыг нь чөлөөлөөд оруулж ирье гэдэг тийм шийдэл гарсан юм уу. Энэ дээр нэг хариулт авмаар байна.

3 дахь асуудал. Бид гурил үйлдвэрлэгч компаниудын гурилын үнэ өндөр байгаа тухай ярьсан. Иргэд олон түмэн ч тэгж ярьж байгаа. Төсөл өргөн

барьж байгаа Засгийн газрын зүгээс ч тэгж ярьж байгаа. Их Хурлын гишүүдээс ч тэгж ярьж байгаа. Гурилын үнэнд бодитой судалгаа, дүгнэлт хийсэн. Энэ дээр манай тэр ШӨХТГ-аас үнэхээрийн энэ хэдэн гурилын үйлдвэрүүд чинь хоорондоо үгсээд зохиомлоор үнэ өсгөчихсөн нь үнэн юм уу Энэ дээр хариулт авмаар байна.

4 дэх асуудал. Хэдэн гурилын үйлдвэрээс болж байж гурилын үйлдвэрийг өөрийг нь түүхий эдээр хангадаг анхдагч газар тариалангийн салбараа татаад унагачих аюул бодитой нүүрлээд байна. Яг энэ шийдэл ярьж байгаатай холбогдуулаад гурилын үйлдвэрийн зарим захирлууд хариуцлагагүй мэдээлэл хийгээд эхэлсэн. Нийгмийн сүлжээгээр. Ийм шийдэл гарах юм бол бид ийм үнээр будаа авна гээд. Хаврын тариалалт эхлэх гэж байна. Энэ тариаланчид чинь улаанбуудай тарих тийм итгэл үнэмшил тогтох юм уу. Гаднаас татварыг нь хөнгөлчихсөн гурил ямар ч тоо хэмжээгүй оруулж ирэхээр шийдлийг төр гаргаад л, тэнд гурилын үйлдвэрүүд нь улаанбуудайн авах үнийг 2023 оны үнээс бараг 30 гаруй хувиар бууруулаад үнэ зарлаж байгаа энэ тэр энэ үйл явцаас чинь болоод энэ газар тариалангийн салбар чинь энэ хариуцлагагүй шийдлүүдийг чинь дааж цаашаагаа явах юм уу. Бид саяхан энэ газар тариалангийн салбар чинь бараг 70-хан мянган тонн бүтээгдэхүүн улаанбуудай авдаг байх үеийг сэргээх гэж бүхэл бүтэн “Атрын 3” дугаар аян эхлүүлээд, байдаг хөрөнгө санхүү бүх юмаа энэ рүү чиглүүлээд, тэгээд 400 гаруй мянган тонн улаанбуудай авдаг болгоод, тэгээд тэр дотор нь бас дараагийн шатын боловсруулах үйлдвэрийнхээ стандартыг хангаж өгөхгүй байгаа будааны эзлэх хувь нь бараг 70, 80 хувьтай байгаад байгаа ийм тохиолдолд ийм эрсдэлтэй шийдлүүд хийх нь хэр зохимжтой гэж ойлгоцгоогоод байна вэ. Бид ер нь явж явж туурга тусгаар улс орон бол энэ үндэсний аюулгүй байдал, хүнсний

хангамжийн аюулгүй байдал, энэ үндэсний үйлдвэрүүдээ тогтвортой байлгах, анхдагч үйлдвэрлэл боловсруулах үйлдвэрүүдийн хоорондын кластер хөгжлийг дэмжих чиглэлийнхээ асуудлыг бодохгүй бол алийн болгон импортлогч хэрэглэгч, бусад улс орнуудын түүхий эдийн хамжлага маягтай явах юм бэ. Тэгээд энэ олон залуучуудаа бид ажлын байраар дотоодоосоо хангаж чадахгүй үндсэндээ ажлын.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн хариулах уу. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Юун түрүүнд би сая танилцуулга дээр хэлсэн. Энэхүү мэдээллийг авахдаа төрийн байгууллагуудын гаргасан мэдээлэл дээр үндэслэсэн. Түүнээс биш аж ахуйн нэгжүүдийн дотоод үйл ажиллагаа руу гүн ороод юмыг нь шалгаад, ингээд тооцоо юмыг нь нягтлаад ингээд явсан юм байхгүй ээ. Яагаад гэхээр бид бол Улсын Их Хурал тодорхой төрийн байгууллагуудын мэдээлэл дээр ажиллах ёстой. Бид бол шүүх байгууллага биш шүү дээ. Тэр утгаараа бол мэдээж аж ахуйн нэгжүүдтэй уулзсан. Тариаланчидтай уулзсан. Санал авсан гэж.

Нөгөө талаас ажлын хэсгийн гаргасан дүгнэлт ер нь бол ажлын хэсгийн барьсан бодлого бол юун түрүүнд 1 дүгээрт ард иргэдийн нэн түрүүнд хэрэгцээтэй байгаа гурилын үнийг буулгах нь зүйтэй гэсэн тал дээр бол ажилласан юм. Би одоо энийгээ аж ахуйн нэгжүүдтэй уулзахдаа ч иүүд хэлсэн. Яагаад гэхээр нэн тэргүүнд бид нар бол мэдээж гурилын бодит үнийг тогтоох нь бол бидний хамгийн том зорилго гэж. Аж ахуйн нэгжүүдтэй уулзахдаа бол мэдээж бас зарим нэгэн зүйлүүд харагдана лээ. Ер нь бол аж ахуйн нэгжүүд өөрөөр хэлбэл гурилын үйлдвэрүүд бол 7-18 хүртэл хувийн

ашигтай ажиллаж байгаа нь бол өөрсдөө ч бас тэгж хэлсэн. Ер нь бол 18 хувийн ашигтай ажиллаж байгаа гэж ярьж байна лээ. Гэхдээ яах вэ зүгээр харахад бол бас гурилын үйлдвэрүүд дээр тодорхой хэмжээнд менежментээ өөрчлөх, тодорхой хэмжээний бас үнэ буулгах дээр бол өөрсдөө ч бас хэлж байна лээ. Бид бол тодорхой арга хэмжээнүүд авъя. Ард иргэдийнхээ төлөө яг бодит үнэ болгохын төлөө бас магадгүй бид нар өөрсдийн дотоод үйл ажиллагаандаа бол менежментийн өөрчлөлтийг хийгээд явахад болохгүй зүйл байхгүй ээ гэж байгаа юм.

Нөгөө талаараа мэдээж бидний хувьд аж ахуйн нэгжүүдээ дэмжээд ингээд явах нь зүйтэй гэж бодож байгаа. Тариаланчдын хувьд жишээ нь нэг тариаланч бас манай нэлээн том аварга тариаланч маань хэлсэн шүү дээ. Хөдөлмөрийн баатар. Жишээ нь Монгол Улсад ерөөсөө хоёрхон улаанбуудай хүлээж авдаг газар байгаа гэж байгаа. Яагаад тэр хүн хоёрхон гэж хэлэв. 1 дүгээрт нь Хөдөө аж ахуйн сан, одоо корпорац шүү дээ. Нэгдүгээрх Хөдөө аж ахуйн корпорац, нөгөөдөх нь Улаанбаатар гурилын үйлдвэр гээд хэлчхэж байгаа байхгүй юу. Энэ өөрөө ямар нэгэн байдлаар бид нарын төрийн бодлого зохицуулах энэ менежмент дутуугаас ямар нэгэн байдлаар бид нар бас тодорхой хэмжээний монопол байдал бий болгочоод байгааг харуулаад байгаа юм. Яг одоо өнөөдөр 12 үйлдвэр байгаагаас бодитоор авч байгаа 70 орчим хувийг нь бол ерөөсөө 4-хөн үйлдвэр авч байгаа байхгүй юу даа.

Дээрээс нь тариаланчдын зовлон бол зөндөө байгаа. Одоо жишээ нь бид нар бол стандартад 1 дүгээрт бол стандартыг өөрчлөх асуудал 1 дүгээрт гарч байгаа байгаа юм байна. 2 дугаарт бол ядаж бид нар бодитоор тэр шинжилгээ стандартыг хийдэг итгэмжлэгдсэн лабораторитой байх жишээ нь бол асуудал гарч ирж байгаа юм.

Одоо манай тариаланчид яаж байна гэхээр ерөөсөө л ачаад өгөөд явуулчихдаг. Очингуут л нөгөөдүүл нь өөрсдийнхөө лабораториор шинжилдэг. Ямар нэгэн итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораториор жишээ нь хүлээж авдаггүй. Энэ бол жишээ нь алдаа шүү дээ. Алдаа. Тэгэхээр энэ зэргийн асуудлууд бол нэлээн яриад байвал олон асуудал байж байна.

Хамгийн гол нь өнөөдөр гадаад зах зээл дээр жишээ нь Оросын гурил гэхэд Улаанбаатарт орж ирэхдээ бараг л 1000-аад төгрөгөөр орж ирэх гээд байна шүү дээ. Гэтэл одоо өнөөдөр дэлгүүрт хэдэн төгрөг байгаа билээ. 2400 гаруй төгрөг байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хоорондын зөрүү, 1000 гаруй төгрөгийн зөрүүг бид нар ямар нэгэн байдлаар ард иргэддээ тодорхой хэмжээний бодит үнэ рүү дөхүүлэх ийм арга хэмжээг бид нар авахаас өөр арга байхгүй. Нөгөөтээгүүр бид нар энэ хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай гээд Улсын Их Хурлын тогтоол оруулахаар төлөвлөж байгаа. Энэ тогтоол дээр юу гэж зааж байна гэхээр жишээ нь наад зах нь бол өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийх нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм.

Дээрээс нь Демпингийн тухай хууль. Гадаадаас орж ирж байгаа үнэхээр одоо Монгол Улсын гурилын үйлдвэрлэлийг унагах ийм зорилготой жишээ нь хямдхан гурил оруулж ирэхээр нөхцөл байдал бий болоод байгаа бол энд нь бид нар зайлиггүй нөгөө нэг Демпингийн тухай хуулиа бол боловсруулан гаргах хэрэгтэй. Дээрээс нь Худалдааны тухай хууль өнөөдөр Монгол Улсад байхгүй байгаа. Худалдааны тухай хуульгүй улс орон байна гэж ерөөсөө байхгүй байхгүй юу даа.

Тэгэхээр худалдааныхаа хуулийг бол жишээ нь Хүнс, хөдөө аж ахуйн яам зайлиггүй оруулж ирэх хэрэгтэй болж байна. Дээрээс нь жишээ нь та бол хэллээ. Одоо салбараа унагах гээд байна

гэж байна. Яг одоо улаанбуудай үйлдвэрлэж байгаа тариаланчдынхаа хувьд бол наад зах нь гэхэд бид нар 100 мянга орчим, мянга орчим тонн улаан буудайг жишээ нь улсын нөөцөд авах. Ер нь олон улсад бол улсын нөөцөд авдаг ийм одоо жишиг байдаг юм байна лээ шүү дээ. Тэгэхээр бид нар энэ талаар бол жишээ нь 100 мянгаад тонныг бол өөрсдөдөө нөөцөд авч байж, энийгээ цаашаагаа биржээр худалдъя гэж байгаа. Ер нь биржээр газар дээрээс нь байна уу ямар нэгэн байдлаар биржээр худалдах ийм боломж бололцоо ч нэе ч гэдэг юм уу ийм байдлаар бид нар дэмжлэг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 4 номер
Амарбаясгалан дарга нэмж тодруулж хариулъя.

Д.Амарбаясгалан: Яах вэ гурил, улаанбуудай 2 мэдээж саллигүй холбоотой 2 зүйл гэдгийг бас ойлгож байгаа. Мэдээж бас тариалангийн салбар эмзэг салбар гэдгийг бас сайн мэдэж байгаа. Мааш сайн судалсан. Ер нь энэ тариалан эрхлэгчдийн хувьд өнөөдрийг хүртэл зах зээлийн зарчмаар бизнес хийж чадалгүй явж иржээ гэж дүгнэгдэж байгаа. Тийм учраас 1 дүгээрт ард иргэд бол хямдхан гурил идэх эрхтэй. Хямд гурил идүүлэх нөхцөлийг төр хангаж өгөх үүрэгтэй. Энэ хүрээндээ Засгийн газар үзэл баримтлал, тогтоолын төсөл орж ирэхэд нь Засгийн газар дээр ярилцаад, эцэслээд алх тогишихдоо татварыг тэглэе, хугацаа тавихгүй байя гэдгийг шийдэж Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа юм.

Хэмжээтэй холбоотой асуудлыг Хүнсний аюулгүйн зөвлөл хэлэлцээд, Засгийн газар жил бүр шаардлагатай импортын гурилын хэмжээг тогтоох бүрэн боломжтой эрх нь бас байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлаар энэ татвар тэглэхтэй холбоотой асуудал нь эцэслэн шийдэгдсэний дараа ямар хэмжээгээр оруулж ирэхтэй холбоотой асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ. Үндэсний

үйлдвэрлэлд эрсдэл учруулахгүй байх тэр бодлогыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Гагцхүү гурилын үйлдвэрлэлээс бий болсон энэ үнийн хөөргөдлийг бид арилгах ёстой. 2019 онд Монгол Улсын хэмжээнд 210 мянган тонн гурил үйлдвэрлэгдсэн. Тэр гурил борлуулагдсан нийт дүн нь 240 тэрбум төгрөг. Гэтэл 2023 онд 190 мянган тонн гурил үйлдвэрлэгдээд борлуулагдсан нийт дүн нь 430 тэрбум төгрөг. Яаж өсөхөөрөө 3 жилийн дотор 2 нугарсан үнэд хүрдэг вэ гэдэг асуудлыг бид өнөөдөр шийдвэрлэх ёстой. Монополын эсрэг Засгийн газар арга хэмжээ авсан. ШӨХТГ-аас очиж акт тавьсан. Хөнгөлөлттэй зээл аваад, зээлийнхээ авахдаа байгуулсан Хүнс, хөдөө аж ахуйн яамтай байгуулсан гэрээндээ нийлүүлэлтийг тогтвортой байлгана. Үнийн тогтвортой бодлогыг баримтална гэж гэрээ байгуулчхаад, гэрээгээ зөрчсөн учраас ШӨХТГ-аас очиж акт тавьсан. Эргээд энэ зөрчлийг нь шүүхэд өгсөн. Шүүх дээр бүтэн жил хагасын хугацаанд шийдэгдэж чаддаггүй. Аргаа бараад Засгийн газраас өнөөдөр импортын татварыг тэглэх асуудлыг оруулж ирж, зах зээл дээр өрсөлдөөнийг бий болгох замаар үнийн хөөсрөлтийг буулгах ийм бодлогыг баримталж байгаа.

Мэдээж энэ гурилын салбар маш их лобби ихтэй салбар байна. Засгийн газрыг дарамталж байна. Ард иргэдийг дарамталж байна. Тариаланчдыг дарамталж байна. Тийм учраас сая ажлын хэсгийн дарга Бат-Эрдэнэ гишүүн танилцууллаа. Тариалангийнхаа салбарыг бүрэн хамгаалалтад ав. Зах зээлийн зарчмаар үнээ тогтоодог тэр боломжийг бүрдүүлж өгнө. Тэгэхийн тулд жил болгон 100 хүртэл мянган тонн улаан буудайг стратегийнхаа нөөцөд авах асуудлыг шийдвэрлэх ийм тогтоол явж байна.

2 дугаарт тариаланчдын нэг том проблем нь хадгалах, агуулах сав байдаггүйн улмаас гурилын

үйлдвэрүүдийн гарт ордог. Гадаа нь аваачиж тариагаа буулгадаг. Нэгэнт буулгачихсан үр тариаг дуртай үнээ хэлээд худалдаж авч байгаа энэ тогтолцоог халахын тулд улаанбуудай биржээр худалдаалах нөхцөл боломжийг Засгийн газрын зүгээс, энэ ажлын хэсгийн зүгээс бас санаачилж оруулж ирж байгаа юм. Ингээд үндсэндээ экспортыг нь чөлөөлнө, хадгалах агуулах нөхцөл боломжийг нь нээж өгнө. Дээрээс нь биржээр үнээ тогтоогоод худалдах боломжийг нь нээж өгнө. Ингэснээр үр тарианы салбар жинхэнэ утгаараа бизнес зарчмаараа хөгжих боломж нь бий болно. Одоо бол 400 мянган тоннд л баригдаж байна. Тэгэхээр цаашаа энэ экспорт нээгдээд 100 мянган тонныг стратегийн нөөцөд аваад ирэхээр зах зээл дээр үнийн өрсөлдөөн болох боломж бүрдэнэ. Гурилын үйлдвэрүүд тариаланчдаас өрсөлдөж авна.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулах юм уу. Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Ийм мэдээлэл хэдүүлээ ярьцаагаад байгаа юм. Яг нарийндаа сая Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос Монголын газар тариалангийн өнөөгийн байдал, цаашидын гарц шийдэл, онц үйлдвэрлэлийн бага хурлыг Дарханд зохион байгуулсан. Эрдэмтэд, судлаачид, тариаланчид, газар тариалангийн зүтгэлтнүүдээ бүгдийг нь оролцуулж байгаад тал бүрийнх нь мэдээллийг сонссон. Монголын газар тариалан ойрын 2, 3 жилд бас учиргүй ургац авчихааргүй бодит нөхцөл нь тийм болчихсон юм байна лээ. Тийм учраас тэрийг засах чиглэлээр сая Байнгын хорооноос тогтоол гаргаад Засгийн газартаа хүргүүлж байгаа. 11 заалттай ч билүү. Энэ бүхнээс харахаар зэрэг ерөөсөө энэ газар тариалангийн үйлдвэрлэлийг чинь энэ жилийн үйл явцад нь нэлээн тийм сөрөг нөлөөлөл орж ирэх нь гэдэг нь их тодорхой байна. Бид хэд биржээр борлуулчихна.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг Бат-Эрдэнэ гишүүн хариулах уу. Амарбаясгалан дарга. Амарбаясгалан даргын микрофоныг өгье. 5 номер.

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя. Шулуухан л хариулъя. Газар тариалангийн салбарт кастын систем бий болсон. Гурилын үйлдвэрээ дагаж явдаг нийт тариаланчдын 30 орчим хувь нь байна. Тэр тариаланчид гурилын үйлдвэртэйгээ шууд холбоотой ажилладаг учраас тэдгээр хүмүүст энэ гурилын үйлдвэрийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлага тулгамддаг. Тэр хэсэг бүлэг бас ийм мэдэгдлийг хийж байгаа. Өнөөдөр Монгол улсын Засгийн газар дээр 3 янзын тариаланчдын холбооноос бичиг ирсэн байна. Жишээ нь өнөөдрийн байдлаар тариалангийн бүс нутгийн тариаланчид малчдын нэгдсэн холбоо гээд нийт 5 хуудас бидэн дээр мэдэгдэл, шаардлага ирж байгаа юм. Холбооны тэргүүн Содхүү, Хөдөлмөрийн баатар Мардан, Хөдөлмөрийн баатар Ганболд, Гавьяат механикжуулагч Даваахүү, Бүрэн-Эрдэнэ компанийн агрономич Мөнхбаатар гээд.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд Амарбаясгалан даргад минут өгье. Гүйцээж тайлбарыг өгье.

Д.Амарбаясгалан: Энд Батжаргал гишүүн ээ, 2, 3 зүйлийг маш тодорхой биччихсэн байгаа юм. Хүнс, хөдөө аж ахуйн сайд 1 сая 250 мянган төгрөгөөр улаанбуудайг авна гэж зарласан боловч 2023 онд 780 мянган төгрөгөөр бид улаанбуудайгаа өгсөн гэдгийг энд биччихсэн ирж байгаа юм. Гарын үсэг зураад тамгаа дарчихсан.

Мэдээж тариалангийн салбарыг эрсдэлд оруулж болохгүй гэдэг зүйлийг Засгийн газарт хэлж байгаа юм. Тэгэхээр тариалангийн салбарыг эрсдэлд оруулахгүй байх энэ хамгаалалтын бодлогыг өнөөдрийн энэ хуулийг дагаж

гарах тогтоолоороо бол зохицуулалтыг хийж өгье гэж ажлын хэсэг үзээд, Батжаргал гишүүн дахиад тайлбарлая. 100 мянган тонныг стратегийн нөөцөд худалдаж авах боломжийг нээж өгнө. Экспортод гарах боломжийг нээж өгнө. Үр тариагаа Хөдөө аж ахуйн корпорацийн мэдэлд байгаа 182 мянган тонны элеваторт хадгалах боломжийг нь бий болгож өгье.

Г.Тэмүүлэн: Хариулт хангалттай гэж үзэх үү. Нэмж тодруулъя. Батжаргал гишүүн. Сүүлийн тодруулга байгаа.

Ж.Батжаргал: Үгүй ээ, үгүй. Энэ одоо янз бүрийн мэдээллүүд ярихаа болимоор байна. Бүх тооцоо судалгаагаар наад будааны чинь үнэ тов тодорхой. Гурилын үйлдвэрээс чинь наад сүлжээ рүүгээ гарч байгаа гурилын чинь үнэ тодорхой, дэлгүүрүүдээсээ иргэд рүүгээ гарч байгаа гурилынх нь үнэ тодорхой, тэгээд яг нарийндаа бид нарын бэлтгэн нийлүүлэлт түгээлтийн тогтолцоо өөрөө тогтоогүйтэй л холбоотой юм байна лээ шүү дээ. Тэгээд үүнийгээ зөв харах ёстой.

2 дугаарт ний нуугүй үнэнийг хэлье. Энэ жилийн улаан буудайн тариалалт буурах нь байна шүү. Одоо үүнийг Монгол Улсын Засгийн газар яаж тариалуулах юм бэ. Тэрийгээ л их тодорхой хэл. Өнөөдөр Төв аймагт 500 тариаланч яг төвийн бүсийн чинь нийт үйлдвэрлэлийн 70 хувийг авч явдаг тариаланчид байж байна. Сайд нь ч очоогүй, Байнгын хороон дарга нь ч очиж чадсангүй. Энэ хэд хэдэн хуулиудыг энэ чуулган дээр бас авч гарахын тулд очиж чадсангүй.

Г.Тэмүүлэн: Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Энэ асуудал өргөн баригдсанаас хойш ингээд 1 сар гаруй хугацаа болчихлоо. Засгийн газар удаа дараа тайлбарлаж байна

Батжаргал гишүүн ээ. Ямар нэгэн байдлаар тариалангийн салбарыг нураах бодлого огт хийгдэхгүй ээ. Магадгүй энд зарим хүмүүсийн эрх ашиг хөндөгдөөд байхыг үгүйсгэхгүй. Энд хүмүүсийн эрх, ашиг хөндөгдөж байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ ард түмэн хямдхан гурил идэх эрхтэй энийг бид заавал хангах ёстой. Энэ тогтоол хурдан батлагдаад, хууль хурдан батлагдаад гараад ирэх юм бол Засгийн газар тариаланчидтайгаа уулзаж нөхцөл байдлаа тодорхойлж энэ гажуудлын засахын төлөө хамтран ажиллах ёстой. Надтай уулзаж байгаа тариаланч дийлэнх нь дэмжиж байгаа шүү дээ. Яагаад тантай уулзаж байгаа тариаланч болгон эсэргүүцээд байгаа юм. Би энийг гайхаж байна. Яагаад ард түмэнд хямд гурил идүүлж гээд явахаар, та бод доо 600гр-тай гурилан боов 9000 төгрөг хүртлээ үнэ өссөн байгааг та зөв гэж бодож байгаа юм уу. Яагаад.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдол холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Ажлын хэсэг байна. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Зарчмын зөрүүтэй санал байна.

Төслийн 1 дүгээр зүйл болон 2 дугаар зүйлийн “улаанбуудайн” гэсний дараа “баяжуулсан” гэснийг тус тус хасах гэсэн ийм саналыг оруулж ирж байна.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. Асуулт, санал байна. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Засгийн газар маань баяжуулсан гурил гээд ороод ирсэн. Манай ажлын хэсэг маань баяжуулсныг нь аваад хаячихсан. Жинхэнэ дампууруулах юм руугаа орж байгаа байхгүй юу. Улам дордож байгаа нөхцөл байдлаа. Баяжуулсан гурил гэдэг нь улаанбуудай тээрэмдээд гарчихсан гурил дээр тодорхой амин дэмүүд нэмж байгаа нэмэгдлийг хэлж байгаа. Тэрийгээ баяжуулсан гурил гэж хэлээд байгаа. Гэтэл одоо бүр тэрийг нь авч хаяад тэгээд ерөөсөө улаанбуудайн гурил л байвал импортоор татваргүй, хэмжээгүй орж ирэх бололцоог нь нээж байгаа. Тэгээд одоо бид хэд чинь хөдөө аж ахуйн орон мөн үү. Тэр цаад гурил үнэтэй гурил идэхгүй гэдэгтэй санал нэг байгаа. Тэр үнэ оруулаад байгаа хүмүүстэй л бид ярих ёстой. Тэр Хөдөө аж ахуйн яам тодорхой нөхцөл бололцоотойгоор банкаар дамжуулж зээл олгохгоод, зээлийнхээ гэрээний хэрэгжилтийг хангаагүй хүмүүстэйгээ яахаараа өдий болтлоо хариуцлагаа ярьж, алдангиа авдаггүй юм тэр хүмүүсээс. Тэрнийх нь золиос болж яахаараа Монголын тариаланчид үйлээ идэх ёстой юм. Би энэ салбартаа, энэ хөдөөтэй 34 жил ухамсарт амьдралаа зориулсан, хамтарсан. Тийм учраас би хэзээ ч 34 жилийнхээ үйл ажиллагааны үзэл баримтлал, үнэт зүйлийнхээ эсрэг нулимахгүй.

Тийм учраас би өнөөдрийн энэ ярьж байгаа санал хураалт юманд чинь оролцохгүй ээ, боломжгүй. Би Монголын Хөдөө аж ахуй, тариаланчдын эсрэг нүгэл үйлдэж чадахгүй.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ. Бат-Эрдэнэ гишүүн ажлын хэсэг.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн ээ, та байж байвал уг нь зүгээр байна. Бид ер нь бол төр ямар нэгэн зохицуулалтыг бол зайлиггүй хийх гэж

байх ёстой. Тэгэхийн төлөө төр байж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт, энэ зохицуулалтыг хууль болгож гаргахын тулд Улсын Их Хурал байж байгаа шүү дээ. Бид өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд гадаад зах зээл дээр хямдхан гурил байж байхад өөрсдөө бид нар мянга гаруй төгрөгийн зөрүүтэй гурилыг ард түмэндээ идүүлж байгаа байхгүй юу даа. Энд бид нар ямар нэгэн зохицуулалтыг хийх ёстой. Зайлшгүй хийх ёстой. Тэгэхийн тулд өнөөдөр бид нар энэ Гаалийн албан татвартай холбоотой энэ хуулийг оруулж ирж байгаа гэж үзэж байгаа шүү. Тийм болохоор энэ хууль бол орж ирж байгаа.

Нөгөөтээгүүр улаанбуудайн гурил гэж яагаад оруулж ирж байгаа юм. Баяжуулсан гэдгийг нь яагаад хасаж байгаа юм бэ гэж. Хүнсний тухай хуульд зааснаар баяжуулсан гэдэг үг бол зайлшгүй байх ёстой байх. Гэхдээ өнөөдөр хэрвээ бид нар яг баяжуулсан гэдгээр явчих юм бол зүгээр энгийн гурил орж ирэх нөхцөл байдал руу хаалттай болчих байхгүй юу даа. Дахиад татвартайгаа үлдчих байхгүй юу. Тийм болохоор бид нар энэ хаалгаа нээж өгч байгаа юм шүү. Тийм болохоор энэ үгийг хассан юм аа гэж.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Санал хураалтыг явуулъя. Ажлын хэсгээс гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “улаанбуудайн” гэсний дараах “баяжуулсан” гэснийг хасах. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжинэ 68,4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс би танилцуулаад явчих уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлсэн байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “улаанбуудайн” гэсний дараах “баяжуулсан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж 68,4 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгээс, Төсөлд доор дурдсан агуулгат тухай 3 дугаар зүйл нэмэх гэсэн санал ирүүлсэн байна.

“3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлсэн байна. Ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,4 хувиар дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүэг хийсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна. Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд болоод ажлын хэсэгт баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ